


Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн
12/27/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АВТО ХИЙГЭЭР ЦЭНЭГЛЭХ СТАНЦ /АХЦС/-ЫН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС



Хяналтын байгууллага:

Шалгуулагч байгууллагын нэр:

Объектын нэр:

Байгууллагын регистрийн дугаар:

Захирлын нэр, утасны дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:

Шалгалтад хамрагдсан барилга байгууламжийн зэрэглэл

Гал түймрийн онц аюултай

Гал түймрийн аюултай 1 дүгээр зэрэглэл

Гал түймрийн аюултай 2 дугаар
зэрэглэл

Гал түймрийн аюултай 3 дугаар зэрэглэл

ШАЛГАХ ЧИГЛЭЛ

№	Хууль, норм, дүрмийн заалт	Шалгалтын асуулт	Шаардлага хангасан эсэх		Тайлбар
			Тийм	Үгүй	
Хууль эрх зүй					
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах.			
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.			
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн			

		үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангах			
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.9	Гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу хийлгэх			
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах.			
6	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.3	Барилга байгууламж, гэр хорооллыг гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай, гал түймэр унтраах үед ашиглах усан хангамжтай байхаар төлөвлөнө.			
7	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9.1	Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй.			
8	"Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.4 заалт	Аянга зайлуулагч, газардуулгын байгууламжийн эсэргүүцлийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлсэн.			
9	Засгийн газрын 2021 оны 21 дугаар тогтоолын хавсралт Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм	Барилга байгууламжид улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан, актаар баталгаажсан эсэх			
Стандарт, норм норматив, дүрэм, журам, зааврийн хэрэгжилт					
1	Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04	Заавал биелүүлэх 4-р хавсралт "Галын аюулаас хамгаалах шаардлага хангасан эсэх"			
2	"Хийн хангамж БНБД42-01- 19"-ийн 8.88 заалт	Хөргөлтийн болон гал унтраах зориулалтын усан сантай			
3	"Хийн хангамж БНБД42-01- 19"-ийн 8.135 заалт	Хий цэнэглэх станцын нутаг дэвсгэр дээгүүр цахилгаан дамжуулах агаарын шугамгүй, цахилгаан тоноглол, хяналт хэмжилтийн багаж, автоматикийн төхөөрөмж тэсрэлтээс хамгаалагдсан хийцтэй.			
4	"Хийн хангамж БНБД42-01- 19"-ийн 8.66 заалт	Баллоны ууршаагүй үлдэгдлийг юүлэх савтай.			
5	Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 3.11.1 заалт	Хий хадгалах сав, насос, компрессорын байр зэрэг нь хийн алдалт илрүүлэх дохиололтой.			

6	Хийн хангамж БНБД42-01-19-ийн 8.52 заалт	Бүлэг резервуар нь далан буюу хашлагатай.			
7	"Хийн аж ахуйн техник ашиглалтын дүрэм"-ийн 8.3 заалт	Хийтэй болон хоосон баллоныг тусад нь хадгалдаг			
8	"Хийн хангамж БНБД42-01-19"-ийн 8.28 заалт	Галын замтай /4.5м-ээс багагүй өргөн/			
9	"Хийн хангамж БНБД42-01-19"-ийн 8.101 заалт	Насос, компрессорын байр, цэнэглэх байр агааржуулалтын системтэй.			
10	"Хийн аж ахуйн техник ашиглалтын дүрэм"-ийн 8.4 заалт	Агуулахад өөр төрлийн хийтэй баллон хадгалдаггүй.			
11	Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 3.6.9 заалт	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан.			
12	"Хийн хангамж БНБД42-01-19"-ийн 8.12 заалт	Хий цэнэглэх станцад хамаарагдахгүй барилга байгууламж хүртэлх зөвшөөрөгдөх зай хэмжээг хангасан			
13	"Хийн хангамж БНБД42-01-19"-ийн 8.16 заалт	Хий цэнэглэх станцын талбай дахь барилга байгууламж хоорондын зөвшөөрөгдөх зай хэмжээг хангасан			

БАТАЛГААЖУУЛАЛТ

Хяналт шалгалт хийсэн газар, хэлтэс, албан тушаал	Хяналт шалгалт зохион байгуулсан албан тушаалтан / овог, нэр/	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан / овог, нэр/
	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/